

МОНГОЛЫН ЗАЛУУ ЭРДЭМТДИЙН ХОЛБООНД ГИШҮҮН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Монголын Залуу Эрдэмтдийн Холбоо /цаашид Холбоо гэх/-ны гишүүн элсүүлэх журмын зорилго нь Монгол Улсын Төрийн бус байгууллагын тухай хууль, Холбооны дүрмийн хүрээнд гишүүн элсүүлэх, гишүүд болон Холбооны хоорондын харилцааг зохицуулахад оршино.
- 1.1. Энэ журам нь Монголын Залуу Эрдэмтдийн Холбооны дүрмийн 3 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.
- 1.2. Холбооны гишүүнчлэл нь гишүүн, хүндэт гишүүн гэсэн хэлбэртэй байна.
- 1.3. Холбоонд шинээр гишүүн элсүүлэх, гишүүдийг бүртгэлийн системд оруулах асуудлыг Холбооны Гүйцэтгэх Алба хариуцан явуулна.
- 1.4. Холбооны гишүүний татварын хэмжээ нь жилд 40,000 (*дөчин мянган*) төгрөг байна.
- 1.5. Холбооны гишүүд нь сайн дурын үндсэн дээр Холбоонд хандив өргөж болно.
- 1.6. Холбооны гишүүдийн эдлэх хөнгөлөлтийн хамрах хүрээ, хэм хэмжээг Удирдах Зөвлөл тогтооно.
- 1.7. Холбооны гишүүн нь сайн дурын үндсэн дээр Холбооны гишүүнээс татгалзах эрхтэй бөгөөд татгалзсан тохиолдолд татвар, хандивыг буцаан олгохгүй.

Хоёр. Гишүүний эрх, үүрэг

- 2.1. Холбооны гишүүн нь дараах эрхийг эдлэнэ:
 - 2.1.1. Холбооны гишүүд нь Холбооны үйл ажиллагааны талаар санаачлага гаргах, сурталчлах, санал шүүмжлэл тавих, дэмжлэгт хамрагдах, Холбооны Удирдах болон Хяналтын зөвлөлд нэрээ дэвшүүлэх;
 - 2.1.2. Холбооноос үзүүлэх хөнгөлөлт, сургалт семинар бусад арга хэмжээнд хамрагдах.
- 2.2. Холбооны гишүүн нь дараах үүргийг хүлээнэ:
 - 2.2.1. Холбооны гишүүн нь холбооны дүрмийг сахин мөрдөх;
 - 2.2.2. Холбооны зорилгыг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулах;
 - 2.2.3. Холбооны үйл ажиллагаанд идэвхитэй оролцож,
 - 2.2.4. Холбооны гишүүний жилийн татварыг төлөх;
 - 2.2.5. Холбоонд гишүүнээр элсэхийг хүссэн хувь хүн дараах бичиг баримтыг бүрдүүлнэ. Үүнд:
 - Гишүүний анкет /Хавсралт/
 - 2 хувь зураг цээж зураг /3x4/
 - Гишүүний татварыг төлсөн баримт

Гурав. Гишүүн элсүүлэх

- 3.1. Холбооны гишүүн нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны болон бусад чиглэлээр ажил эрхэлдэг бакалавраас дээш эрдмийн зэрэг цол бүхий 45 хүртэл насны хүн бүрт нээлттэй.
- 3.2. Холбоо нь шинээр гишүүн элсүүлэхдээ ардчилсан зарчмыг баримтлах бөгөөд арьс өнгө, нас, хүйс, тахир дутуу байдал, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодлоор нь иргэдийг ялгаварлан гадуурхахгүй.
- 3.3. Гишүүнээр элсэхээр хүсэлт гаргасан иргэний бичиг баримтыг Гүйцэтгэх алба хүлээн авч ажлын 10 хоногийн хугацаанд гишүүний үнэмлэхийг олгоно.